

# Үнэт цаасны үнийн хязгаарлалт, түүний үр нөлөө

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Биржүүд зах зээл дэх үнийн хэт өөрчлөлт, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор өдрийн үнийн хязгаарлалт (price up/down limit), аюулгүйн горим (circuit breaker), арилжаа зогсоох (trading halt) гэсэн хязгаарлалт, хяналтуудыг түгээмэл ашиглаж байгаа бөгөөд зарим улс орнуудад өөрийн улсын эрх зүйн орчны зохицуулалтад нийцсэн аргачлалыг боловсруулан, мөрдөж байна. Үнэт цаасны зах зээл өндөр хөгжсөн Америк, Европ тивүүдэд өдрийн үнийн хязгаарлалтыг түгээмэл ашиглаж байгаа бол уг зах зээл шинээр болон харьцангуй сүүлд хөгжсөн Ази тив болон Зөвлөлт холбоот улс задарсны дүнд бий болсон Казакстан, Эстони, Гүрж болон ОХУ зэрэг бусад орнуудад аюулгүй горим, арилжаа түр зогсоох аргачлалыг түлхүү хэрэглэж буй нийтлэг зүй тогтол ажиглагдаж байна.

Монгол улсын хувьд эдгээр аргачлалыг хослуулан хэрэглэх, үнэт цаасны зах зээл хөгжиж байгаа тул аль болох уян хатан зохицуулалт хийх, арилжааг түр зогсоож, үргэлжлүүлэхтэй холбогдсон эрхүүдийг Биржид олгох нь тохиромжтой.

<b>ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b>	<b>1</b>
<b>1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО</b>	<b>3</b>
<b>2. АСУУДАЛ СУДЛАГДСАН БАЙДАЛ</b>	<b>3</b>
2.1. Үнийн хязгаарлалт хийх аргачлалууд	3
2.2. Олон улсад үнийн хязгаарлалтын талаар хийгдсэн судалгаа	5
2.3. Монгол улсад үнийн хязгаарлалтын талаар хийгдсэн судалгаа	8
<b>3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b>	<b>8</b>
3.1. Судалгаа хийхэд ашигласан аргачлал	8
3.2. Судалгаанд ашигласан мэдээлэл, баримт бичгүүд	9
<b>4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН</b>	<b>9</b>
4.1. Бусад биржүүдтэй харьцуулсан судалгаа	9
4.2. Монгол улсын зарим үнэт цаасны шинжилгээ	9
<b>5. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ</b>	<b>18</b>
<b>НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20</b>
Зарим улс орны жишээ	20
<b>ЭХ СУРВАЛЖ</b>	<b>22</b>
<b>ХАВСРАЛТ</b>	<b>24</b>

## 1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагууд одоогийн байдлаар өдрийн үнийн хязгаарлалтын зарчмыг мөрдөж байна. Үнийн хязгаарлалтыг тогтоохдоо өдрийн үнийн хэлбэлзэл өмнөх өдрийн хаалтын ханшаас дээш, доош 15 хувиас хэтрэхгүй байхаар арилжаа эрхлэх байгууллагуудын журамд тусгажээ.

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нь уг хязгаарлалтаас өмнө сүүлийн хэлцлээс үнийн өөрчлөлтийг хязгаарлах аргачлал ашиглаж, сүүлийн хэлцлийн үнэ өмнөх хэлцлийн үнээс 15 хувиар дээш эсвэл доош хязгаарт багтаж байхаар журамдаа тусган мөрдөж байсан.

Дээрх аргачлалууд нь тус тусын давуу болон сул талуудтай бөгөөд тэдгээрийг илүү тодорхой болгох, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж, цаашлаад Монгол улсын үнэт цаасны зах зээлд үнийг хязгаарлах аль аргачлал илүү тохиромжтой болохыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.

## 2. АСУУДАЛ СУДЛАГДСАН БАЙДАЛ

### 2.1. Үнийн хязгаарлалт хийх аргачлалууд

Биржүүд зах зээлд үнийн огцом өөрчлөлтөөс сэргийлэхийн тулд өдрийн үнийн хязгаарлалт (price up/down limit), аюулгүйн горим (circuit breaker), арилжаа зогсоох (trading halt) гэсэн хязгаарлалт, хяналтуудыг түгээмэл ашиглаж байна.<sup>1</sup> Эдгээр аргачлалуудаас хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй 2 аргачлалыг харьцуулахад дараах ялгаатай байна. Үүнд:

Өдрийн үнийн хязгаарлалт (price up/down limit)	Аюулгүйн горим (circuit breaker)
<ul style="list-style-type: none"> <li>→ Тухайн өдрийн хувьд үнэт цаасны үнэ дээш, доош хэлбэлзэж болох хязгаарыг тогтоодог.</li> <li>→ Арилжаа зогсоох шаардлагагүй.</li> <li>→ Арилжааны үе бүрт ижил байна.</li> <li>→ Үнийн хязгаараас давсан захиалгыг системд хүлээж авдаггүй.</li> <li>→ Үнэт цаасны төрөл тус бүрээр тохируулна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>→ Үнэт цаасны үнэ тодорхой хэмжээнд хүрэхэд арилжааг түр зогсоож, үргэлжлүүлэх байдлаар үнийг дахин тодорхойлдог.</li> <li>→ Дуудлага худалдааны үед дуудлага худалдаа явуулах хугацааг уртасгадаг. (МХБ ашиглаж буйтай ижил)</li> <li>→ Үргэлжилсэн арилжааны үед арилжааг зогсоож эсвэл зогсоохгүйгээр дуудлага худалдаа явуулдаг. (МХБ ашиглаж буйтай ижил)</li> <li>→ Арилжааны үе бүрт ялгаатай байхаар тохируулах боломжтой.</li> <li>→ Бүх үнэт цаасыг хамрахаар бүхэлд нь тохируулж болно.</li> </ul>

<sup>1</sup> Word Federation of Exchanges (2021). Circuit breakers and other market safeguards.

Дээрх аргачлалуудын аль аль нь үнийн хязгаарлалт тогтоож байгаа боловч үнийн өдрийн хязгаарлалт нь анхнаасаа тухайн арилжаанд хязгаараас давсан захиалга авахгүй тул үнийн хэлбэлзлийг тодорхой хэмжээнд барьж байх аргачлал бол, аюулгүй горим нь бүх захиалгыг системд хүлээн авч, тухайн үнийн хязгаарлалт дээр хэлцэл биелэх тохиолдолд арилжаанд оролцогчдод сануулга өгч, дахин дуудлага худалдаа хийх маягаар арилжааг үргэлжлүүлэн явуулах аргачлал юм.

Дуудлага худалдааны үргэлжлэх хугацаа нь биржээс хамаарч өөр өөр байдаг боловч 2-10 минутын хооронд хэлбэлздэг ба жижиг, хөрвөх чадвар багатай хувьцааны хувьд илүү урт байдаг. Жишээлбэл, Германы бирж (Deutsche Börse) нь тогтворгүй байдлаас үүдэлтэйгээр дуудлага худалдааг санамсаргүй хугацаагаар сунгадаг бол Солонгосын хөрөнгийн бирж 20 минутын дуудлага худалдаа явуулдаг ч шаардлагатай тохиолдолд 10 минутаар хугацааг нь уртасгадаг.

Ихэнх тохиолдолд дээрх болон бусад аргачлалуудыг биржүүд хослуулан ашигладаг бөгөөд зарим улс орнуудад өөрийн хууль, эрх зүйн орчинд нийцүүлсэн, олон улсад түгээмэл биш аргачлалуудыг ч хэрэглэж байгаа юм. Тухайлбал, Хонконгийн хөрөнгийн бирж нь хосолмол аргачлал ашиглан, аюулгүйн горимын үед арилжааг зогсоохгүйгээр тодорхой хязгаарын хүрээнд арилжаагаа үргэлжлүүлэн явуулдаг байна.<sup>2</sup>

Үнийн хязгаарлалт хийж буй эдгээр аргачлалууд нь ямар нэг жишиг үнээс тооцож, хязгаарлах үнийг гаргаж ирдэг. Жишиг үнийг сонгох үндсэн 2 төрлийн аргыг биржүүд ашигладаг байна. Үүнд:

1. Тогтмол - Тогтмол буюу статик үнээс хязгаараа тогтоох бөгөөд ихэвчлэн өмнөх өдрийн хаалтын үнэ эсвэл нээлтийн үнэ зэрэг байдаг.
2. Динамик - Жишиг үнэ нь тухайн арилжааны өдрийн туршид өөр өөр утга авах боломжтой байх бөгөөд ихэвчлэн сүүлийн хэлцлийн үнэ, сүүлийн хэд хэдэн хэлцлийн дундаж үнэ гэх мэт байж болдог.

Эдгээр аргуудыг биржүүд хослуулсан байдлаар хэрэглэх нь элбэг байдаг. Тогтмол жишиг үнийг ашигласнаар тухайн өдөр өмнөх өдрөөс томоохон өөрчлөлт гаргахгүй байлгахад удирдах боломжтой бол динамик үнийг хэрэглэснээр гэнэтийн томоохон өөрчлөлт зах зээлд гарахгүй байх нөхцөлийг бий болгодог давуу талтай юм.

Биржүүд дээрх хязгаарлалтыг зах зээлд үнийн хэт савлагаа үүсэхээс сэргийлэхийн тулд ашигладаг ба арилжааны үеэр дээрх аргыг хэрэглэснээр гишүүд болон бусад арилжаанд оролцогчдод хэт савлагаа үүсч буй үед мэдээлэлтэй байх боломжийг олгодог байна. Түүнчлэн Насдак, Хонконгийн хөрөнгийн бирж гэх мэт дийлэнх биржүүд тухайн өдөр эсвэл сард хэдийд аюулгүйн горим ашиглан ямар үнэт цаасны арилжааг түр зогсоон дуудлага худалдаа явуулсан тухай цаг, минутаар нь дэлгэрэнгүй гаргаж олон нийтэд мэдээлдэг тул зах зээлд оролцогчид ч мөн мэдээлэл сайтай арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Зарим биржүүдийн хувьд үнэт цаасны үнийн хязгаарлалтыг ялгаатай байдлаар тогтоох, эсвэл зарим тохиолдолд үнийн хязгаарлалтгүй явуулах нь түгээмэл ажиглагддаг. Тухайлбал, Шэньжэний хөрөнгийн бирж IPO хийсэн хувьцаа болон бүртгэлийг

<sup>2</sup> Hong Kong Stock Exchange (2021). Securities Market, Trading FAQ.

түдгэлзлүүлсэний дараа түүнийг сэргээж бүртгэж буй тохиолдолд эхний арилжааны өдөр үнийн хязгаарлалт үйлчлэхгүй байхаар журамласан бол 2005 онд Тайваний эрх бүхий газраас IPO хийсэн хувьцаануудын эхний 5 арилжааны өдөрт үнийн хязгаарын дүрэм үйлчлэхгүй байх арилжааны дүрмийг гаргасан. Энэ дүрэм хэрэгжсэний дараагаас хоёрдогч зах зээлийн өгөөж хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн эхний 2 долоо хоногт онолын үнээс харьцангуй бага байсан ба үнэ богино хугацаанд засварлагдаж, арилжааны дүн нэмэгдсэн байна. Мөн түүнчлэн Шанхайн хөрөнгийн бирж Стар маркет дээр ижил төрлийн зохицуулалт мөрдөгддөг.

### **Аюулгүйн горим (Circuit-breaker)**

Аюулгүйн горимыг хамгийн анх Нью-Йоркийн хөрөнгийн бирж нэвтрүүлсэн бөгөөд 1987 оны хөрөнгийн зах зээлийн уналтын дараагаар бий болсон зохицуулалт юм. 2008 оны санхүүгийн хямралын дараагаар биржүүд энэ тохиргоог илүүтэй хэрэглэх болсон.<sup>3</sup> Түр хугацаанд арилжааг зогсоосноор хөрөнгө оруулагчдад позицоо дахин үнэлэх, захиалгаа хянах, шийдвэр гаргах, түүнийгээ өөрчлөх хугацаа олгодог. Арилжаа зогсоох хугацаа нь бирж бүрийн хувьд ялгаатай байх бөгөөд хэдэн секундын турш эсвэл бүтэн өдрийн турш ч байж болно.

## **2.2. Олон улсад үнийн хязгаарлалтын талаар хийгдсэн судалгаа**

Үнийн хязгаарлалтын талаар олон улсын хэмжээнд маш олон судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн бөгөөд хязгаарлалт байх хэрэгтэй эсэх гэхээсээ илүүтэй тухайн хязгаарлалт нь ямар байдлаар хэрэгжих (тогтмол эсвэл динамик эсвэл хосолсон), хязгаарлалтын хувь хэмжээ ямар байх нь зүйтэй талаар төвлөрч судалжээ. Сүүлийн жилүүдэд Ковид-19 цар тахлын улмаас үнэт цаасны зах зээлд үнийн огцом өөрчлөлт, савлагаа бий болж байгаагаас биржүүд өөрсдийн үнийн хязгаарлалт хийх зохицуулалтыг дахин хянаж үзэх, өөрчлөх хандлагууд ажиглагдаж эхэлсэн байна.

Үнийн хязгаарлалтын үр дүнгийн талаар судлаачид өдийг хүртэл хуваагдмал байр суурьтай<sup>4</sup> байдаг бөгөөд нэг талаас зах зээлд үнийн хэт савлагааг бий болгохгүй байх давуу талтай боловч нөгөө талаас зах зээлд шударга, ил тод зарчмыг үгүйсгэсэн, зах зээлд зөв үнэ тогтох боломжийг олгохгүй байх зэрэг сул талуудтай гэжээ.

Аюулгүйн горимын зах зээлд үзүүлэх эерэг нөлөөний талаар олон судалгааны ажлууд хийгдсэн байдаг. Аюулгүйн горимын онолын талаарх ихэнх судалгааны ажилд зах зээл тогтворгүй үед аюулгүйн горим нь арилжааны эрсдэлийг бууруулдаг гэж тодорхойлсон байна. Корвин болон Липсон (2000)<sup>5</sup> нар Нью-Йоркийн хөрөнгийн биржийн арилжааны түр зогсолтын үед шинээр захиалга оруулах, цуцлах үйлдлүүд нэмэгддэг гэсэн бол Голдштейн (2015)<sup>6</sup>-ийн үзэж буйгаар аюулгүйн горим нь хөрөнгийн зах зээлд өдрийн үнийн хэлбэлзлийг бууруулахад эерэг нөлөөтэй ажээ.

<sup>3</sup> World Federation of Exchanges (2021). Circuit breakers and other market safeguards.

<sup>4</sup> Mai, A. A., & Khairy, E. (2017). The Effect of Daily Stock Price Limits on the Investment Risk: Evidence from the Egyptian Stock Market

<sup>5</sup> Corwin, Sh. A., & Lipson, M. L. (2000). Order Flow and Liquidity around NYSE Trading Halts.

<sup>6</sup> Goldstein, M. A. (2015). Circuit Breakers, Trading Collars, and Volatility Transmission Across Markets: Evidence from NYSE Rule 80A.

2021 онд Дэлхийн биржүүдийн холбооноос гаргасан судалгааны ажилд Америк, Европ, Ази, Номхон далайн улс орнууд, Ойрхи Дорнод, Африкийн нийт 43 биржийг судалгаандаа хамруулсан бөгөөд аюулгүйн горим нь зах зээл дэх хэт үнийн хэлбэлзлийг бууруулах, үнэт цаасны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, хамгийн зөв үнийг тодорхойлох зэрэг эерэг нөлөөтэйг дурдсан байна. Эдгээр биржүүдийн 67% нь үүсмэл хэрэгслийн, 84% нь энгийн хувьцааны арилжааны үеэр аюулгүйн горимыг хэрэгжүүлэх зохицуулалтай байна<sup>7</sup>. Тус судалгаанаас бас нэг онцлох зүйл нь үнэт цаасны зах зээл өндөр хөгжсөн улс орнуудад, тухайлбал Америк болон Европ тивийн улс орнуудад, өдрийн үнийн хязгаарыг харьцангуй бага хувьтай (5-20%) байхаар зохицуулсан бол сүүлийн 40-50 жилд үнэт цаасны зах зээл нь эрчимтэй хөгжиж буй Азийн орнуудад үнийн хязгаарлалтын зохицуулалт харьцангуй уян хатан, шинэлэг аргачлал ашиглагдаж байна. Тухайлбал, Хонконг улсад өдрийн үнийн хязгаар болон аюулгүйн горимыг хослуулсан шинэлэг аргачлалыг ашиглаж байна.

Өдрийн үнийн хязгаарлалт нь аюулгүйн горимтой харьцуулбал харьцангуй энгийн зохицуулалт бөгөөд тодорхой хязгаараас давсан захиалгыг хүлээж авдаггүй тул арилжаа эхлэхэд л тухайн үнэт цаасны үнэ тодорхой байх аргачлал юм. Энэ аргачлалыг дийлэнх улс орнуудад аюулгүйн горимтой хамтад нь хэрэглэж байна.

Өдрийн үнийн хязгаарлалт нь хувьцааны үнийн хэлбэлзлийг бууруулах, арилжааг саадгүй, зогсоохгүйгээр зохион байгуулах эерэг талтайгаас гадна туршлагагүй, бодит бус шийдвэр гаргах хандлагатай арилжаанд оролцогчдын хувьд зөв хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах хугацаа олгодог<sup>8</sup> гэжээ. Түүнчлэн өдрийн үнийн хязгаарлалт нь жижиг хөрөнгө оруулагчдыг хамгаалдаг тул тэдгээр хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг<sup>9</sup> байна.

Харин өдрийн үнийн хязгаарлалтын сөрөг үр дагавруудаас дурдвал зөв үнэ тогтох боломжийг олгохгүй байх, арилжаа зах зээлийн зарчмаар явагдах боломжийг бууруулах, үнийн хэт савлагааг тухайн үед хязгаарлаж чадсан ч бусад үнэт цаасны хувьд тодорхой хугацааны дараагаар тухайн үнийн хэлбэлзэл нөлөөлж, илэрч гарсаар байдаг<sup>10</sup> ба хэдий өдрийн хязгаарлалт хийсэн ч үнэт цаасны үнэ буурахаас сэргийлж чадахгүй, үнэ тогтворжихгүй байх<sup>11</sup> тохиолдол ч гарсан байдаг.

Түүнчлэн аюулгүйн горим нь зарим сул талтай болохыг хэд хэдэн судалгаагаар гаргаж ирсэн байдаг. Тухайлбал, аюулгүйн горим нь зах зээл дэх хэт үнийн хэлбэлзлээс сэргийлж, зах зээлд зөв үнийг тогтоох давуу талтай боловч түүнтэй зэрэгцэн авах, зарах захиалгын

<sup>7</sup> World Federation of Exchanges (2021). Circuit breakers and other market safeguards.

<sup>8</sup> Li, H., Zheng, D., & Chen, J. (2014). Effectiveness, cause and impact of price limit- Evidence from China's cross-listed stocks.

<sup>9</sup> Chen, G., Rui, O.M., & Wang, S. S. (2005). The Effectiveness of Price Limits of and Stock Characteristics: Evidence from the Shanghai and Shenzhen Stock Exchange.

<sup>10</sup> Abdelzaher, M. H., & Elgiziry, K. (2017). The Effect of Daily Stock Price Limits on the Investment Risk: Evidence from the Egyptian Stock Market

<sup>11</sup> Wang, D., Chong, T. & Chan (2014). Price Limits and Stock Market Volatility in China.

үнийг зөрүүг хэт нэмэгдүүлэх<sup>12</sup>, арилжааг түр зогсоосны дараагийн өдөр хувьцааны үнийг хэлбэлзэл буурахгүй байх<sup>13</sup> зэрэг тохиолдлууд ажиглагддаг байна.

Үнийн хязгаарлалт хийх аргачлалууд нь хэр үр дүнтэй байгаа талаар маш олон улс орны жишээ, мэдээлэл дээр судалгаа, шинжилгээ хийгдсэн байдаг. Тухайлбал, Японы Токиогийн хөрөнгийн биржийн жишээнээс үзэхэд үнийн хязгаартаа хүрсэн үнэт цаасны хувьд бусад хязгаартаа хүрээгүй үнэт цаастай харьцуулбал энгийн үнийн хэлбэлзлийн түвшиндээ очиход харьцангуй урт хугацаа шаардагдаж байжээ<sup>14</sup>. Тус биржийн хувьд үнийн хязгаарлалтын харьцангуй хэлбэлзэл өндөр байж болохоор тогтоосон тул үнэт цаасны үнэ тухайн хязгаарт хүрэх нь түгээмэл биш ба нэгэнт хязгаартаа хүрсэн бол тухайн үнэт цаасны арилжаа дараагийн өдрөө маш өндөр болж, бусад үнэт цаасны арилжааны идэвх нь багасаж байсан дүр зураг ажиглагджээ.

Харин БНХАУ-ийн зах зээлийн жишээг ашиглан хийгдсэн судалгаанд дурдсанаар өдрийн үнийн хязгаарлалт нь жижиг хөрөнгө оруулагчдыг хамгаалах боловч томоохон хөрөнгө оруулагчид тус хязгаарлалтыг зүй бусаар ашиглаж байгаа нь харагджээ. Тухайлбал, томоохон, туршлагатай хөрөнгө оруулагчид аливаа үнэт цаасны үнийг өдрийн хязгаарт нь хүргээд маргааш нь өндөр үнээр хувьцаагаа зарах арга хэрэглэж байгаа нь<sup>15</sup> өдрийн үнийн хязгаарлалт хийх зохицуулалт үр дүнгүй байгааг харуулсан хэрэг болсон юм. Энэ нь хөрөнгө оруулагчдын хувьд ижил тэгш мэдээлэлтэй бус, туршлагатай болон туршлагагүй маш олон төрлийн оролцогчидтой хөгжиж буй улс орнуудын хувьд тулгамдсан асуудал бөгөөд өдрийн үнийн хязгаарлалтаас илүүтэй өөрсдийн улс орны онцлог тохирсон шинэлэг аргачлал хэрэглэх нь зүйтэйг судлаачид мөн дурдсан байна.

Түүнчлэн өдрийн үнийн хязгаарлалт нь зах зээлд тухайн үнэт цаасны бодит буюу тэнцвэрт үнэ тогтоход саад учруулан, бодит үнэ тогтох хугацааг удаашруулдаг тухай Тайвань<sup>16</sup>, АНУ<sup>17</sup>, Египет<sup>18</sup>, Солонгос<sup>19</sup> зэрэг маш олон улс орны бодит жишээн дээрээс ажиглагдсан байна. Солонгос улсын мэдээллийг ашиглан хийгдсэн судалгаанаас үзэхэд үнийн хязгаар нэмэгдэх нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлж байсан тул зах зээл үүсгэгчдийн идэвх суларч, үнэт цаасны хөрвөх чадвар багасахад хүрсэн байна.

Үнийн хязгаарлалттай болон хязгаарлалтгүй зохицуулалтын ялгааг тодруулахын тулд БНХАУ-ын мэдээллийг ашиглан хийгдсэн нэгэн судалгааг дурдах нь зүйтэй. Хятад улс нь 1992-1996 оноос бусад үеүдэд өдрийн үнийн хязгаарыг хэрэгжүүлж байсан. Үнийн

<sup>12</sup> Guillaumie, C., Loiacono, G., Winkler, C., & Kern, S. (2020). Market impacts of circuit breakers – Evidence from EU trading venues.

<sup>13</sup> Lee, C. M. C., Ready, M. J. & Seguin, P. J. (1994). Volume, volatility and New York Stock Exchange trading halts.

<sup>14</sup> Kim, K. A., & Rhee, S. G. (1997). Price Limit Performance: Evidence from the Tokyo Stock Exchange.

<sup>15</sup> Chen, T., Zhenyu, G., Jibao, H., Wenxi, J. & Wei, X. (2019). Daily price limits and destructive market behaviour.

<sup>16</sup> Huang, Y. Sh., Fu, T. W., & Ke, M. Ch. (2001). Daily price limits and stock price behaviour: Evidence from the Taiwan Stock Exchange.

<sup>17</sup> Veld-Merkoulova, Y. (2003). Price Limits in Futures Markets: Effects on the Price Discovery Process and Volatility.

<sup>18</sup> Abdelzaher, M. H., & Elgiziry, K. (2017). The Effect of Daily Stock Price Limits on the Investment Risk: Evidence from the Egyptian Stock Market

<sup>19</sup> Wonse, K. & Sungjae, J. (2019). Effects of a Price Limit Change on Market Stability at the Intraday Horizon in the Korean Stock Market.

хязгаарлалт нь үнийн огцом хэлбэлзлээс сэргийлдэг тул үнийн хэт их хэлбэлзлийг бууруулах, спекулятив болон паник арилжааны сөрөг нөлөөллийг бууруулах давуу талтай<sup>20</sup>. Судалгааны үр дүнд дараах 3 зүйлсийг онцолсон байна.

- Үнийн хязгаар нь түр зуурын хэлбэлзэл болон арилжааны хэвийн бус үйл ажиллагааг бууруулах нөлөөтэй байна.
- Идэвх султай хувьцаануудын хувьд үнийн хатуу хязгаарлалт нь тогтворгүй байдлыг бууруулдаг.
- Уналтын дараагаас зах зээл сэргэхэд үнийн хязгаар нөлөөлж байна.

Түүнчлэн тухайн улсын авлигалын түвшин өндөр, хуулийн хэрэгжилт сул бол үнийн хязгаарыг илүүтэй хэрэгжүүлэх хандлагатай байдаг<sup>21</sup> бөгөөд хөрөнгийн зах зээл манипуляцаас сэргийлэхийн тулд үнийн хязгаарлалт ашиглах нь түгээмэл байна.

### **2.3. Монгол улсад үнийн хязгаарлалтын талаар хийгдсэн судалгаа**

Манай улсын хувьд зөвхөн үнийн хязгаарлалт, түүний үнэт цаасны зах зээлд үзүүлэх нөлөөллийн талаар хийгдэн, хэвлэгдэн гарсан судалгаа одоогоор байхгүй байна.

Гэсэн ч олон улсын жишээтэй адил зарим талууд үнийн хязгаарлалт нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үр дүнтэй аргачлал гэж үзэж байгаа бол албан бус мэдээ, хэлэлцүүлгүүдээс үзэхэд хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогч мэргэжлийн этгээдүүдийн зүгээс тус хязгаарлалт нь үнийг чөлөөтэй хөдлөх боломжийг олгоогүйгээс арилжааны идэвх сул байхаас гадна, үнэт цаасны зах зээлд хөгжилд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл гэж үзэх нь олонтаа байна.

## **3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

### **3.1. Судалгаа хийхэд ашигласан аргачлал**

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд үндсэн 2 төрлийн аргачлалыг ашигласан. Нэгдүгээрт, бусад улс орны биржүүдийн үнийн хязгаарлалтын хувь хэмжээ, зохицуулалтыг харьцуулах аргачлал ашиглан судалсан бол, хоёрдугаарт Монгол улсын бүртгэлтэй компаниудын үнэт цаасны үнийн хэлбэлзлийг түүхэн мэдээлэлд анализ хийх аргачлал ашигласан болно.

Харьцуулсан судалгааны аргын үндсэн зорилго бол эмперик байдлаар нэгтгэх таамаглалыг баталгаажуулах явдал бол түүхэн өгөгдөл анализ хийснээр тухайн үнэт цаас үнийн хязгаартаа хүрч буй шалтгааныг олж илрүүлэх зорилготой юм.

<sup>20</sup> Kim, A., Liu, H. & Yang, J. (2013). Reconsidering Price Limit Effectiveness

<sup>21</sup> Kim, H. (2010). Dynamic causal linkages between the US stock market and the stock markets of the East Asian economies.



### **3.2. Судалгаанд ашигласан мэдээлэл, баримт бичгүүд**

Биржүүдийн үнийн хязгаарлалт хийж буй хувь хэмжээ болон зохицуулалтыг тэдгээр биржүүдийн албан ёсны цахим хуудас болон албан ёсны судалгааны ажлууд, дэлхийн биржүүдийн холбооны санал асуулга зэргээс түүвэрлэн ашигласан болно.

Түүнчлэн Монгол улсад өдрийн үнийн хязгаарлалт хэрхэн хэрэгжиж буйг дүгнэх үүднээс Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудаснаас үнэт цаасны үнийн түүхэн мэдээлэл, тухайн үнэт цаас гаргагчийн талаар гарсан мэдээллийг авч шинжилгээ хийсэн.

## **4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН**

### **4.1. Бусад биржүүдтэй харьцуулсан судалгаа**

Үнэт цаасны зах зээл өндөр хөгжсөн улс орнуудад үнийн хязгаарлалт хийх хувь хэмжээ харьцангуй бага буюу 5-20 хувь байгаа бол зах зээл шинээр хөгжиж буй улс орнуудын хувьд 40-50 хүртэл хувь байгаа бөгөөд зарим улс орнуудад хязгаарлалтгүй байх тохиолдол байна.

Биржүүдийн дийлэнх нь буюу талаас илүү хувь ямар нэг үнийн хязгаарлалтын ашиглаж байгаа бөгөөд аль болох хэд хэдэн аргачлалуудыг хослуулан ашиглаж байна. Биржүүдийн хослуулан хэрэглэж буй хамгийн түгээмэл аргачлал нь өдрийн үнийн хязгаар болон аюулгүй горимын тохиргоонууд байна. Зарим тохиолдолд арилжаа түр зогсоох аргачлалыг ашиглаж байна. Түүнчлэн зарим улс орнууд өөрсдийн онцлогт тохируулсан тусгай аргачлал боловсруулан ашиглах нь бий.

Үнийн хязгаарлалт хийх аргачлалууд нь давуу болон сул талтай байгааг олон орны жишээ харуулж байна. Тухайлбал, өдрийн үнийн хязгаарлалт нь зах зээлд гэнэтийн савлагаа үүсэхээс сэргийлж байгаа боловч тухайн үнэт цаасны хувьд зөв үнэ тогтох боломжийг үгүй болгож эсвэл хойшлуулж байгаа нь зах зээлд оролцогчдод сөрөг нөлөөтэй байна. Харин аюулгүйн горим тохиргоог ашигласнаар үнийн хязгаарлалтыг илүү үр дүнтэй зохион байгуулж болох бөгөөд арилжаанд оролцогчдод нөхцөл байдлын талаар мэдээлэл хүргэж, тэдний бүхий л захиалгыг авсны үндсэн дээр тэнцвэрт үнийн тооцооллыг илүү бодитой болгодог байна.

Түүнчлэн бусад улс орнууд урт хугацааны тоон мэдээлэлд үндэслэн үнийн хязгаарлалтын аргачлалуудаа сайжруулсаар ирсэн байна. Тухайлбал, АНУ-д биржүүдийн төлөөллөөс бүрдсэн хороо нь үнийн хязгаарлалтын хөтөлбөрт үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрхэн сайжруулах, ямар өөрчлөлт оруулах талаар нэгдэн ажиллаж байна.

### **4.2. Монгол улсын зарим үнэт цаасны шинжилгээ**

Бид судалгааг илүү үр дүнтэй болгох үүднээс Монгол улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй зарим үнэт цаасыг сонгон авч, үнийн хязгаарлалт хэрхэн нөлөөлж буйг шинжилж үзсэн болно.

### Ард Санхүүгийн Нэгдэл ХК (Жинст Увс ХК)


Жинст Увс ХК: 2017 оны 12 дугаар сарын 15-аас 12 дугаар сарын 27 хүртэл дараалсан 9 өдөр тухайн компанийн хувьцааны ханш 15 хувиар өссөн байна. Үүний шалтгаан нь 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр СЗХ Жинст Увс ХК-д Хөрөнгө оруулагч Үндэстэн хаалттай ХК нэгтгэхийг зөвшөөрсөнтэй холбоотой. 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс урвуу нэгдэл хийсэн Хөрөнгө оруулагч Үндэстэн ХК болон Жинст Увс ХК-ийн хувьцаа МХБ-дээр арилжаалагдаж эхлэсэн бөгөөд урвуу нэгдэл хийхээс өмнөх хаалтын ханшаар тухайн компанийн арилжааг эхлүүлсэн нь зах зээлд, ялангуяа нэгдэж буй компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг зөрчсөн байж болзошгүй асуудал болсон байна.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь “Жинст Увс” ХК-тай урвуу нэгдэл хийх замаар нээлттэй компани болсноор 2019 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс МХБ дээр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа арилжаалагдаж эхлэсэн.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны ханш 2021 оны 1 дүгээр сарын 18-аас 22-ны өдөр хүртэл харгалзан 15%, 13%, 10%, 13%, 14.5%-ийн өсөлт үзүүлсэн нь тухайн компани Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индекст дахин багтсан, мөн 2020 оны тайлангаа олон нийтэд танилцуулсан зэрэг үйл явдлуудтай холбоотой байна.

2021 оны 2 дугаар сарын 16-наас 18-ны өдрүүдэд хувьцааны ханш харгалзан 15%, 12%, 14.4%-ийн өсөлт үзүүлсэн бөгөөд үүний шалтгаан нь 2 дугаар сарын 15-ны өдөр Ард Санхүүгийн Нэгдлээс хувьцаа эзэмшигчдэдээ Ард койны урамшуулал олгох шийдвэр гарсантай холбоотой байна. Үүнээс харвал үнийн хязгаартай үед тухайн хувьцааны ханштай холбоотой аливаа мэдээ олон хоногийн турш хувьцааны ханшид нөлөөлж байна.

График 1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Айтүүлс ХК

Хувьцааны ханш 2017 оны 11 дүгээр сарын 16, 17, 20, 21-ний өдрүүдэд дараалан 15 хувиар өссөн байна. Айтүүлс ХК-ийн анхдагч зах зээлийн захиалга 2017 оны 11-р сарын 01-ний өдрөөс 11-р сарын 10-ний өдөр хүртэл үргэлжилсэн бөгөөд захиалга нийлүүлэлтээсээ 3 дахин давсан байна. Айтүүлс ХК-ийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 2017 оны 11-р сарын 16-ний өдөр эхэлсэн бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлмэгц дараалан 4 өдөр үнийн хязгаарт хүрсэн нь хөрөнгө оруулагчид тухайн компанид хөрөнгө оруулах сонирхол өндөр байсныг харуулж байна.

Анхдагч зах зээлд 100 төгрөгөөр олон нийтэд санал болгосон хувьцаа 52 долоо хоногийн байдлаар 70.62-123.55 төгрөг байгаа нь урт хугацааны хөрөнгө оруулагчдын хувьд сайн хөрөнгө оруулалт болж чадаагүйг харуулж байна.

График 2. Айтүүлс ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

График 2-оос харвал хувьцааны ханш 15 хувийн өсөлтөд хүрэхэд арилжааны дүн нэмэгдсэн ба хувьцааны ханш харьцангуй тогтворгүй болсоноор арилжааны идэвх буурсан байна.

### АПУ ХК


АПУ ХК-ийн хувьцааны ханш 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдөр 15 хувиар өссөн ба дараагийн 5 арилжааны өдрүүдэд хувьцааны ханш буурсан байна.

АПУ ХК-ийн хувьцааны ханш 2021 оны 8 дугаар 5 болон 6-ны өдрүүдэд 15 хувиар өссөн ба үүний шалтгаан нь 2021 оны 8 дугаар сарын 3-ны өдөр АПУ ХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг 2021 оны эхний хагас жилийн санхүү үйл ажиллагааны тайланг цахим хэлбэрээр олон нийтэд танилцуулсантай холбоотой юм. Тайлант хугацаанд гарсан дараах эерэг мэдээнүүд нь хувьцааны ханш дараалан 2 өдөр хязгаартаа хүртэл өсөхөд нөлөөлсөн гэж үзэж байна.

- Цэвэр борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35 хувиар өсч, 305 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашиг 80 хувийн өсөлт үзүүлсэн байна.
- Тайлант үеийн байдлаар улсын төсөвт төлсөн татварын хэмжээ өмнөх оны үзүүлэлтээс 42 хувиар өссөн;
- "Соёлоор гоёно", "Тогтвортой хөгжил", "Мод бид хоёр" төслүүдийг амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна.
- Өмнөх үетэй харьцуулахад 4.3 дахин илүү хөрөнгө оруулалт хийв.
- Экспортын үйл ажиллагааны хувьд БНХАУ, ОХУ-д идэвхитэй үйл ажиллагаа явуулав.
- Нийт ашгийн түвшин 152 тэрбум төгрөг, үйл ажиллагааны ашиг 99 тэрбум, татварын дараах ашиг 81.3 тэрбум төгрөгний үр дүнтэй ажилласан байна.

Дээрх эерэг мэдээнүүд нь хувьцааны ханш 2 өдөр дараалан 15 хувь өсөхөд нөлөөлсөн байна.

График 3. АПУ ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

График 3-аас харвал хувьцааны ханш дараалан 2 өдөр 15 хувиар өсөхөд харгалзан 22,584 болон 103,842 ширхэг хувьцаа арилжаалагдсан ба дараагийн өдрүүдэд 216,379 болон 121,967 ширхэг хувьцаа арилжаалагдаж арилжааны идэвх нэмэгдсэн ба ханш 3 өдөр дараалан буурсан байна. Үүнээс харвал хувьцааны ханш хязгаартаа хүрсэний дараагаас арилжааны идэвх нэмэгдэж байгааг харж болно.

### Дархан нэхий ХК

Дархан нэхий ХК-ийн хувьцааны ханш 2013 оны 1 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд 15 хувиар өссөн ба дараагийн 2 өдөр 13 хувийн бууралт үзүүлсэн байна. Мөн 2013 оны 5 дугаар сарын 9 болон 10-ны өдрүүдэд харгалзан 14 хувийн өсөлт, 13 хувийн бууралтыг

үзүүлсэн байна. 2013 онд Дархан нэхий ХК-ийн хувьцааны ханш нийт 8 удаа үнийн хязгаартаа хүрсэн байна.

2016 оны 3 дугаар сарын 31 болон 4 дүгээр сарын 4-ний өдрүүдэд хувьцааны ханш харгалзан 15 хувийн өсөлт болон 13 хувийн бууралтыг үзүүлсэн байна.

Дархан нэхий ХК-ийн хувьцааг 1,000 хуваах замаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор тус үйл ажиллагаа бүрэн хийгдэж дуусах хүртэл компанийн үнэт цаасны арилжааг 2020 оны 7 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн түр зогсоосон билээ. Хувьцааг хуваахтай холбоотой үйл ажиллагаа дууссан тул үнэт цаасны арилжааг 2020 оны 8 дугаар сарын 06-ны өдрөөс нээсэн байна. Арилжааг нээсэн өдрөөс ханш 13 хувь болон 15 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

2019 оны 11 дугаар сарын 22 болон 12 дугаар сарын 2-ны өдрүүдэд харгалзан 15 хувийн бууралт болон 15 хувийн өсөлт, 2020 оны 8 дугаар сарын 18, 19-ны өдрүүдэд харгалзан 14.22 хувийн бууралт, 15 хувийн өсөлт үзүүлсэн байна.

2021 оны 3 дугаар сарын 12, 15-ны өдрүүдэд хувьцааны ханш дараалж 15 хувиар өссөн бөгөөд тухайн өдрүүдэд харгалзан 122,973 болон 238,816 ширхэг хувьцаа арилжаалагдсан ба дараагийн өдрүүдэд 859,209 болон 550,984 ширхэг хувьцаа арилжаалагдаж арилжааны идэвх нэмэгдсэн байна.

Дархан нэхий ХК-ийн хувьцааны үнээс харвал ханш 15 хувиар өссөн /буурсан/ тохиолдолд дараагийн өдөр мөн ижил хэмжээгээр буурсан /өссөн/ байна. Мөн үнэ 15 хувиар өссөн үед дараагийн арилжааны өдөр арилжааны дүн харьцангуй өссөн байна.


### **Улсын их дэлгүүр ХК**

2020 оны 6 дугаар сарын 29-нд хувьцааны ханш 15 хувиар буурсан ба энэ өдөр 125 ширхэг хувьцаа арилжаалагдсан ба дараагийн өдрүүдэд ханш 15 хувь болон 13 хувиар өссөн ба арилжигдсан ширхэгүүд харгалзан 2,610 болон 1,006 болсон байна.

2021 оны 9 дүгээр сарын 3, 6, 7-ны өдрүүдэд хувьцааны ханш 15 хувь, 13 хувь, 12 хувийн өсөлтийг үзүүлсэн бөгөөд тухайн өдрүүдэд харгалзан 58.3 сая 33.77 сая, 173.8 сая төгрөгний арилжаа хийгдсэн ба харин 2021 оны 9 дүгээр сарын 13, 14, 15, 17-ны өдрүүдэд хувьцааны ханш 15 хувиар, 16-ны өдөр 12 хувиар буурахад арилжааны дүнгүүд харгалзан 21.3 сая, 2 сая, 1.3 сая, 14 сая болон 1.7 сая төгрөг болж буурсан байна.

2020 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Улсын их дэлгүүр ХК-ийн барилгад гал түймрийн аюул нүүрлэж, томоохон гарз хохирол тохиолдсонд 6-р сарын 8-ны өдөр хувьцааны ханш 13 хувиар унасан байна.

График 4. Улсын их дэлгүүр ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

График 4-өөс харвал хувьцааны ханш үнийн хязгаарт хүрсэн тохиолдолд үнийн савлагаа их байгааг харж болохоор байна. Мөн үнийн хэлбэлзэл их үед арилжигдсан ширхэгийн хэлбэлзэл өндөр байхаар байна.

**Мандал даатгал ХК**

2021 оны 2 дугаар сарын 17 болон 18-ны өдрүүдэд хувьцааны данш дараалан 15 хувиар өссөн ба арилжааны дүн харгалзан 81.8 сая ₮, 65.4 сая ₮ байна.

График 5. Мандал даатгал ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

График 5-аас ханш үнийн хязгаарт хүрсэнээс хойш үнэ болон арилжигдсан ширхэгийн хэлбэлзэл нэмэгдэж байгааг харж болох бөгөөд ханш 15 хувиар нэмэгдсэний дараагийн 2 өдөр ханш 8 хувь болон 6.5 хувиар унасан ба 391.4 сая, 118 сая төгрөгний арилжаа хийгдсэн байна. Үүнээс харвал үнийн хязгаар нь арилжааны дүн болон хувьцааны үнийн хэлбэлзлийг бий болгосон байна.

### Монгол шуудан ХК

Хувьцааны ханш 2021 оны 3 дугаар сарын 10, 11, 12, 15, 16-ны дараалсан 5 өдөр 15 хувиар өссөн ба харгалзан 1825, 11894, 2010, 4340, 2090 ширхэгийн хувьцаа арилжигдсан ба дараагийн өдрүүдэд 55,748 болон 25,223 ширхэгийн хувьцаа арилжаалагдаж арилжааны идэвх нэмэгдсэн байна.

График 6. Монгол шуудан ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг ба үнийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

График 6-аас харвал хувьцааны ханш 5 өдөр дараалж 15 хувиар өссөний дараагийн өдөр арилжааны дүн огцом өссөн ба хувьцааны ханш харьцангуй тогтворгүй болсон байна.

### Үндэсний хувьчлалын сан ХХХОС

Үндэсний хувьчлалын сан ХХХОС-ийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2020 оны 10 дугаар сарын 26-нд эхлэсэн. 2021 оны 3 дугаар сарын 12 болон 15-ны өдрүүдэд нэгж эрхийн үнэ дараалан 2 өдөр 15 хувиар, 2021 оны 4 дүгээр сарын 21-ээс 4 дүгээр сарын 23-ны өдрүүдэд 15 хувиар өссөн ба 2021 оны 4 дүгээр сарын 26-наас 4 дүгээр сарын 30 хүртэл дараалан 5 өдөр 15 хувиар буурсан байна.

График 7. Үндэсний хувьчлалын сан ХОС-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж


График 7-оос харвал хувьцааны ханш 15 хувиар өссөн үед арилжааны дүн өссөн ба ханш 15 хувиар буурсан өдрүүдэд арилжааны дүн буурсан байна. Үүнээс харвал хувьцааны ханш үнийн хязгаарт тулсан өдрүүдэд арилжааны дүнгийн хэлбэлзэл ихтэй байна.

### Таван толгой ХК

Таван толгой ХК-ийн хувьцааны ханш 2017 оны 2 дугаар сарын 21, 22, 23-ны өдрүүдэд дараалан 15 хувийн өсөлтийг үзүүлсэн бөгөөд харгалзан 99.4 сая, 11.56 сая, 70.28 сая төгрөгний арилжаа хийгдсэн байна. Хувьцааны ханшийн энэхүү өсөлт нь МХБ дээр 2 дугаар сарын 20-ний өдөр Таван толгой ХК-ийн 2016 оны жилийн эцсийн тайланг хүлээн авсан гэх мэдээ гарсан ба тайлан мэдээний эерэг үзүүлэлттэй холбоотой байна. Үнийн хязгаарлалтын зохицуулалт нь тухайн компанитай холбоотой аливаа мэдээний хувьцааны ханшид нөлөөлөх хугацааг удаашруулж байна.



График 8. Таван толгой ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

### Лендмн ББСБ ХК

Лендмн ББСБ-ын анхдагч зах зээлийн захиалга 2018 оны 2 дугаар сарын 21-нээс 03 дугаар сарын 7-ны өдөр хүртэл үргэлжилсэн бөгөөд захиалга нийлүүлэлтээсээ 16.5 дахин давж хаагдсан. Хоёрдогч зах зээлийн арилжаа 2018 оны 3 дугаар сарын 14-нд эхлэсэн ба арилжаа эхлээд 5 өдөр дараалж 15 хувиар өссөн байна. Үүнээс харвал үнийн хязгаарлалтын зохицуулалт нь тухайн хувьцааны бодит эрэлт болон үнэ цэнийг тусгаж чадахгүй байна.

График 9. Лендмн ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Ард Кредит ББСБ ХК

Ард Кредит ББСБ ХК-ийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдөр эхлэсэн бөгөөд арилжаа явагдсанаас хойш нийт 9 удаа үнийн хязгаарт хүрсэн байна.

2021 оны 2 дугаар сарын 18-наас 2 дугаар сарын 23-ны өдрүүдэд хувьцааны ханш 15 хувиар өссөн ба 200,000-800,000 ширхэгийн хувьцаа арилжаалагдаж байсан бол дараагийн арилжааны өдрүүдэд 1 саяас 2.5 сая ширхэг хувьцаа арилжаалагдаж арилжааны идэвх нэмэгдсэн байна.

График 10. Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны арилжигдсан ширхэг болон үнийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## 5. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дийлэнх биржүүд аюулгүйн горимыг өдрийн үнийн хязгаарлалттай хослуулан ашиглаж байна. Үүний гол зорилго нь зах зээлийг уян хатан байлгаж, зах зээлийн зарчмаараа хөгжих боломжийг олгоход оршиж байгаа юм. Биржүүдийн гол үүрэг нь зөв үнийг тодорхойлох учир энэ үүргээ хэрэгжүүлэх, аль болох уян хатан зохицуулалт хийх боломжоор олгох шаардлагатай байдаг байна.

Үнэт цаасны үнэ нь зах зээлийн нөхцөл байдлыг зөвөөр тусгадаг тул үнийн хэлбэлзэл нь муу зүйл биш юм. Тухайн үнийн хэлбэлзэл ямар хүчин зүйлээс хамаарч байгааг ялгаж ойлгох нь чухал. Судалгаанаас үзэхэд үнийн хязгаар тогтоосноор тэнцвэрт үнэ тогтоход саад учруулж, эсрэгээрээ илүү их хэлбэлзлийг үүсгэхээр байна. Биржийн үйл ажиллагаа нь санхүүгийн хэрэгслийн бодит үнийг тодорхойлох, шударга ил тод үйл ажиллагаа явуулах боловч үнийн хязгаарлалтаас үүдэн энэхүү үүргээ бүрэн биелүүлэх боломжгүй нөхцөл байдалд хүрч байна. Тухайлбал, өдрийн үнийн хязгаарлалт нь үнийн хэт савлалтаас сэргийлж байгаа ч зөв үнэ тогтох хугацаа удаашрах, зах зээлийн хөрвөх

чадвар буурах, томоохон хөрөнгө оруулагчид зах зээлийг урвуулан ашиглах зэрэг сөрөг үр дагаврууд олонтаа тохиолдож байна.

Түүнчлэн улс орнууд зөвхөн өдрийн үнийн хязгаарлалтаас илүүтэй аюулгүй горим болон түүнтэй хослуулсан аргачлалыг дийлэнх тохиолдолд хэрэглэж байгаа нь ажиглагдаж байна. Тэр дундаа ази номхон далайн үнэт цаасны зах зээл хөгжиж буй улс орнуудад өдрийн үнийн хязгаарлалт нь мөн өндөр (20+) хувьтай байх нь элбэг байна.

